БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр Дугаар А/185 Улаанбаатар хот

Дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/728 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Цагдаагийн хэлтэс Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Газар зохион байгуулалтын албаны дарга Улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагч Нийгмийн даатгалын хэлтсийн Нийгмийн даатгалын улсын байцаагч Татварын хэлтсийн Татварын улсын байцаагч Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Хөдөө аж ахуйн тасгийн дарга
Нарийн бичгийн дарга:	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хяналт шинжилгээ үнэлгээ, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн

2.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД